



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/67

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн  
гэрчилгээг хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Н.Дэрийлаа (СИ45051511)-ийн эзэмшлийн Хэрлэн сумын 1 дүгээр баг (Хэрлэн), Хийд гудамжид байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 1952 м<sup>2</sup> газраас 506 м<sup>2</sup> газрыг иргэн Г.Баярболд (ЖБ87070876)-д, үлдсэн 1446 м<sup>2</sup> газрыг Н.Дэрийлаад 41 жилийн хугацаатайгаар хэсэгчлэн шилжүүлэн эзэмшүүлсүгэй.


2.Иргэн Г.Баярболдын эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмших эрхийн цахим гэрчилгээг олгон гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Сүнгээ)-д үүрэг болгосугай.

4.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Н.Дэрийлаа, Г.Баярболд нарт үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/536 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ